ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ



2026 MAY

МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН ТОЙМ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

АГУУЛГА

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ 1

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ 2

2.1. Олон улсын эдийн засаг 2

2.2. АНУ-ын эдийн засаг 2

2.3. БНХАУ-ын эдийн засаг 4

2.4. Түүхий эдийн зах зээл 5

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ 6

3.1. Эдийн засгийн өсөлт 6

3.2. Инфляц 7

3.3. Улсын төсөв 8

3.4. Мөнгөний нийлүүлэлт 8

3.5. Нийт зээл 9

3.6. Гадаад худалдаа 10

3.7. Төлбөрийн тэнцэл, ханш 13

График, хүснэгтүүдийн жагсаалт

График 1 АНУ-ын инфляц, гадаад худалдаа 3
График 2 БНХАУ-ын үнийн индекс, гадаад худалдаа 4
График 3 Монголын эдийн засгийн өсөлт, 1-р улиралд 6
График 4 Инфляц ба Бодлогын хүү 7
График 5 Улсын төсөв 8
График 6 Мөнгөний нийлүүлэлт 9
График 7 Банкны салбарын зээл 10
График 8 Нийт экспорт ба импорт 10
График 9 Экспортын голлох бүтээгдэхүүн 11
График 10 Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнийн түвшин 11
График 11 Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн түвшин 12
График 12 Импортын голлох бүтээгдэхүүн 12
График 13 Төлбөрийн тэнцэл 13

I. СТАТИСТИКИЙН ТОЙМ

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
УЛИРЛЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026Q1	**2025Q4**	**2025Q1**	
Бодит ДНБ	тэрбум төгрөг	6,736	34,332	6,244	7.9%
Ажилгүйдлийн түвшин	%	5.7%	5.6%	5.4%	
Дундаж нэрлэсэн цалин	мянган төгрөг		2,878	2,622	
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M4	**2026M3**	**2025M4**	
Гадаад худалдааны үзүүлэлтүүд					
Нийт экспорт	сая ам.доллар	6,813	4,889	4,243	60.6%
Зэс	сая ам.доллар	3,080	2,188	1,374	124.2%
Нүүрс	сая ам.доллар	2,515	1,756	1,759	43.0%
Нийт импорт	сая ам.доллар	3,669	2,477	3,559	3.1%
Хэрэглээ	сая ам.доллар	1,066	749	1,217	-12.4%
Хөрөнгө оруулалт	сая ам.доллар	1,350	844	1,360	-0.7%
Аж үйлдвэрлэл	сая ам.доллар	372	260	264	40.9%
Шатахуун	сая ам.доллар	872	618	711	22.6%
Тэнцэл	сая ам.доллар	3,145	2,412	683	4.6x
Түүхий эдийн үнэ (Primary Commodity Prices, IMF, Монголбанк)					
Зэс	$/тонн	12,891	12,529	9,173	40.5%
Нүүрс (хилийн)	$/тонн	68.6	68.9	68.8	-0.2%
Алт	$/трой унц	4,720	4,893	3,222	46.5%
Газрын тос	$/баррел	103	99	67	53.6%

ҮЗҮҮЛЭЛТҮҮД	НЭГЖ	ТАЙЛАНТ ХУГАЦАА	ӨМНӨХ ҮЕ	ӨМНӨХ ОНЫ МӨН ҮЕ	ЖИЛИЙН ӨСӨЛТ
САРЫН ҮЗҮҮЛЭЛТҮҮД					
		2026M4	**2026M3**	**2025M4**	
Улсын нэгдсэн төсөв					
Төсвийн тэнцвэржүүлсэн тэнцэл	тэрбум төгрөг	- 1,425	-1,360	-58	2356%
Төсвийн тэнцвэржүүлсэн орлого	тэрбум төгрөг	8,947	6,303	8,488	5.4%
Төсвийн нийт зарлага	тэрбум төгрөг	10,372	7,663	8,546	21.4%
Мөнгөний бодлого					
М2 нийлүүлэлт	тэрбум төгрөг	50,995	49,411	40,706	25.3%
ХҮИ (2023 суурь)	индекс	125.6	122.1	114.1	10.1%
Бодлогын хүү	%	12%	12%	12%	-
Хүү ба ханш					
Нэрлэсэн ханш (хугацааны эцэст)	Төгрөг/$	3,576	3,569	3,542	1.0%
Төгрөгийн хадгаламж	%	11.88%	11.84%	11.99%	−0.9%
Валютын хадгаламж	%	4.19%	3.24%	4.16%	0.7%
Төгрөгийн зээл	%	17.53%	17.59%	17.20%	1.92%
Валютын зээл	%	10.08%	10.23%	11.70%	−13.9%
Гадаад валютын нөөц					
Нийт	сая ам.доллар	7,327	7,188	5,135	42.7%

II. ГАДААД ЭДИЙН ЗАСАГ

2.1. Олон улсын эдийн засаг

АНУ-ын Сенатын санал хураалтаар 54–45 хувийн харьцаатайгаар Кэвин Уорш Холбооны Нөөцийн Банкны тэргүүнээр томилогдлоо. Түүнийг албан тушаалдаа томилогдсоны дараа Ерөнхийлөгч Доналд Трамп ирэх дөрвөн жилийн хугацаанд бодлогын хүүг бууруулах чиглэлд анхаарч ажиллах шаардлагатайг онцолсон байна. Гэвч одоогийн нөхцөлд инфляцын дарамт өндөр хэвээр байгаа тул бодлогын хүүг бууруулах боломж харьцангуй хязгаарлагдмал байна. Тухайлбал, 2026 оны 4 дүгээр сард АНУ-ын инфляц 3.8 хувьд хүрч, 2023 оны дунд үеэс хойших хамгийн өндөр түвшинд хүрсэн нь мөнгөний зөөлөн бодлого явуулах орон зайг хумиж байна.

Үүний зэрэгцээ АНУ–Ираны зөрчил үргэлжилсээр байгаа ба гал зогсоох бодит үр дүнтэй хэлэлцээрт хараахан хүрээгүй, Ормузын хоолой хаалттай хэвээр байна. Энэхүү нөхцөл байдал нь дэлхийн газрын тосны нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж, нөөц буурах эрсдэлийг бий болгож байна. Олон улсын эрчим хүчний агентлагийн үнэлгээгээр ойрын хугацаанд дайн намжсан ч 2026 оны 10 дугаар сар хүртэл зах зээлд нийлүүлэлтийн дутагдал үргэлжлэх төлөвтэй байгааг дурджээ.

Ийнхүү геополитикийн тодорхойгүй байдал нэмэгдэж буй нөхцөлд олон улсын дипломат уулзалтууд эрчимжиж, дэлхийн эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах оролдлого нэмэгдэж байна. Үүнд АНУ–БНХАУ-ын төрийн тэргүүнүүдийн уулзалт, мөн Европын холбоо, G20 зэрэг олон талт болон бүс нутгийн дээд хэмжээний уулзалтууд багтаж байна. Геополитикийн өндөр эрсдэлтэй бүс нутгуудад гал зогсоох хэлэлцээрийг дэмжих, нийлүүлэлтийн сүлжээ болон эрчим хүчний зах зээлийг тогтвортой байлгах чиглэлээр хамтын ажиллагааг бэхжүүлэх бодлогын арга хэмжээнүүд хэрэгжиж эхэлж байгаа нь дэлхийн эдийн засагт эрсдэлийг бууруулах зорилгыг агуулж байна.

2.2. АНУ-ын эдийн засаг

АНУ-ын хувьд өмнөх сард Төв банкны тэргүүн солигдож, мөн Ерөнхийлөгч Доналд Трамп томоохон бизнес эрхлэгчдийн хамтаар БНХАУ-д айлчилсан уулзалт нь хамгийн гол үйл явдал боллоо. Ираны дайнаас үүдэлтэйгээр олон улсын хэмжээнд эрчим хүчний тасалдал бий болж, шатахуун, түлшний үнийн өсөлтөөс үүдэн инфляцын дарамт сүүлийн 2 сарын хугацаанд нэмэгдсээр байна. Ийнхүү энэ нөхцөл байдлаас үүдэн АНУ-д эрчим хүчний үнийн өсөлт суурь инфляцыг[1] бүтэн жилийн турш 2 хувиас дээш түвшинд хадгалах магадлалтай байгаа тул мөнгөний зөөлөн бодлого явуулах орон зай зах зээлд бага байна.

[1] *Суурь инфляц: Хоол хүнс болон эрчим хүч (шатахуун, нефть гэх мэт)-ний үнийг хасаж тооцсон инфляцын үзүүлэлт юм. Хүнш, шатахууны үнэ нь геополитик, улирлын нөлөөнөөс шалтгаалж тогтворгүй байдаг тул суурь инфляцыг тооцохдоо хасч авч үздэг. ХНС бодлогын хүүний шийдвэрийг гаргахдаа суурь инфляцад илүү ач холбогдол өгдөг.*

“Goldman Sachs” байгууллагын зүгээс эрчим хүний үнийн өсөлтөөс шалтгаалж бодлогын хүүг бууруулах хугацааг 1 улирлаар хойшлуулж Төв банкийг 2026 оны 12 сард болон 2027 оны 3 сард бодлогын хүүг бууруулна гэж үзжээ.

График 1 АНУ-ын инфляц, гадаад худалдаа



Эх сурвалж: U.S. Bureau of Labor Statistics



Эх сурвалж: U.S. Bureau of Labor Statistics

2026 оны 4 дүгээр сард АНУ-ын инфляцын жилийн өсөлт 3.8%-д хүрч, 2023 оны 5 сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрлээ. Ираны дайнаас үүдэлтэй нефтийн үнийн өсөлтийн нөлөөгөөр эрчим хүчний үнэ 17.9%-иар өссөн (шатахуун 28.4%, түлш 54.3%), мөн орон сууц (3.3%), хүнсний инфляц (2.3%) нэмэгджээ. Суурь инфляц буюу хүнс, шатахууны үнийг хассан инфляцын түвшин 2.8% болж өмнө жилийн мөн үетэй ижил түвшинд хадгалагдаж байна.

Гадаад худалдааны хувьд 2026 оны 4 дүгээр сард АНУ-ын импортын үнэ өмнөх оны мөн үеэс 4.2%-иар өссөн бол экспортын үнэ 8.8%-иар өссөн нь 2022 оноос хойших хамгийн өндөр жилийн өсөлтүүдийн нэгт тооцогдож байна.

Импортын үнийн өсөлтөд түлш, эрчим хүчний үнэ (ялангуяа нефть) огцом нэмэгдсэн, мөн хөрөнгө оруулалтын бүтээгдэхүүн, аж үйлдвэрийн түүхий эд, хэрэглээний барааны үнэ өссөн нь голлон нөлөөлсөн бол экспортын хувьд газрын тос, химийн бүтээгдэхүүн зэрэг аж үйлдвэрийн түүхий эдийн үнэ, мөн шар буурцаг, мах зэрэг хөдөө аж ахуйн бүтээгдэхүүний үнийн өсөлт голлон нөлөөлжээ.

2.3. БНХАУ-ын эдийн засаг

БНХАУ-ын эдийн засгийн хувьд Ираны дайнтай холбоотойгоор түүхий эдийн үнийн өсөлтөөс шалтгаалсан нийлүүлэлтийн гаралтай эрсдэлүүд бий болж байгаа хэдий ч бодлогын түвшинд эдийн засгийн тогтвортой байдлыг хадгалах, дотоод эрэлтийг дэмжих, мөн нийлүүлэлтийн сүлжээг төрөлжүүлж үйлдвэрлэлийн зардлын дарамтыг бууруулах чиглэлд анхаарч байна.

БНХАУ нь Ираны нефтийн гол худалдан авагч хэвээр ба тус улсын эдийн засгийг дэмжихийн зэрэгцээ өөрийн эрчим хүчний нийлүүлэлтийг баталгаажуулах бодлогыг үргэлжлүүлж байна.

График 2 БНХАУ-ын үнийн индекс, гадаад худалдаа



Эх сурвалж: Trading Economics



Эх сурвалж: Trading Economics

БНХАУ-ын хэрэглээний үнийн индексээр хэмжигдэх инфляцын түвшин 1.2 хувь, харин үйлдвэрлэгчдийн үнийн индекс 2.8 хувиар өсөж, энэхүү хоёр үзүүлэлт 2022 оны 7 сараас хойших хамгийн өндөр түвшинд хүрсэн байна. Үнийн өсөлтийн гол шалтгаан нь мөн адил эрчим хүч болон түүхий эдийн үнэ өссөнтэй холбоотой ба үүний зэрэгцээ Хөдөлмөрчдийн баярын үеийн хэрэглээ нэмэгдсэн нь дотоод эрэлтийг дэмжиж, улмаар үйлдвэрлэгчдийн өртөг өссөн нөлөө хэрэглэгчдийн худалдан авч буй бараа бүтээгдэхүүний үнийг өсгөх нөлөө үзүүлсэн байна. Гэсэн ч хүнсний үнийн дарамт харьцангуй сул байгаа нь инфляцын өсөлтийн тодорхой хэмжээнд хязгаарлах гол шалтгаан болж байна.

Гадаад худалдааны хувьд 4-р сард экспортын хэмжээ 359.4 тэрбум ам.долларт хүрч 14.1 хувийн өсөлттэй гарсан бол импорт 274.6 тэрбум ам.долларт хүрч 25.3 хувийн өсөлт үзүүлсэн байна. Экспортын өсөлтийн хувьд Ираны дайны нөлөөгөөр түүхий эдийн зардал өсөхөөс өмнө компаниуд бүтээгдэхүүнээ Зүүн Өмнө Ази, Европын улсууд руу хурдацтай нийлүүлсэн нь нөлөөлсөн бол импортын хувьд дотоод үйлдвэрлэлүүдийн түүхий эдийн эрэлт нэмэгдсэнтэй холбоотойгоор өндөр өсөлтийг үзүүлсэн байна.

2.4. Түүхий эдийн зах зээл

2026 онд геополитикийн нөлөөгөөр түүхий эдийн үнэ өндөр хэвээр байх ч 2027 оноос газрын тосны үнэ буурах, зэс, нүүрсний үнэ тогтвортой хадгалагдах, харин алтны үнэ өссөөр байх ерөнхий төлөв ажиглагдаж байна.

Хүснэгт 1 Түүхий эдийн спот үнэ олон үнийн таамаглал

Түүхий эд	Спот үнэ	2026Q2	2026Q3	2026Q4	2027Q1	2026	2027
Брэнт газрын тос, $/баррель	$104	$107	$94	$86	$82	$94	$79
Зэс, $/сая тонн	$13,656	$13,516	$13,659	$13,660	$13,661	$13,424	$13,665
Алт, $/унц	$4,532	4,555	4,575	4,624	4,673	4,676	4,752
Австралийн коксжих нүүрс, $/сая тонн	$239	$236	$238	$240	$243	$237	$248

Эх сурвалж: Bloomberg Terminal, 5 сарын 21-ны байдлаар

2026 оны 5 сарын 21-ний өдрийн байдлаар брэнт газрын тосны үнэ 104 ам.доллар/баррельтай тэнцэж байна. 2026 оны 3-р улирлаас үнэ харьцангуй буурч эхлэх төлөвтэй байгаа ба энэ нь дайны нөхцөл байдал ойрын хугацаанд намжих тохиолдолд хүчинтэй байна. Ийнхүү Блүүмбэрг байгууллагаас гаргаж буй 30 гаруй байгууллагын дундаж төсөөллөөр газрын тосны үнэ 2026 оны эцэст 86 ам.доллар/баррель, харин 2027 онд 79 ам.доллар/баррельтай тэнцэнэ гэж үзэж байна. 2026 онд нийлүүлэлтийн талын тасалдал өндөр, мөн нөөцийн бууралтаас шалтгаалж үнэ харьцангуй өндөрт хадгалагдах бол 2027 онд нийлүүлэлт сэргэж, богино хугацааны шокын нөлөө арилна хэмээн таамаглажээ.

Зэсийн үнэ 13,656 ам.доллартай тэнцэж байна. 2026 болон 2027 онд $13,500–13,700 орчимд тогтвортой хадгалагдах төлөвтэй байгаа ба аж үйлдвэрийн эрэлт, ялангуяа БНХАУ-ын дэд бүтэц болон шинэ технологийн салбарын эрэлт тогтвортой байгаагаас шалтгаалж байна.

Харин алтны үнийн хувьд өндөрт хадгалагдах хандлагатай байна. Одоогийн спот ханш 4,532 ам.доллартой тэнцэж байгаа ба 2026 оны эцэст 4,624 ам.доллар, харин 2027 онд 4,752 ам.доллартой тэнцэх төсөөлөлтэй байна. Энэхүү үнийн өсөлт нь геополитикийн эрсдэл болон санхүүгийн зах зээлийн тодорхойгүй байдлаас шалтгаалан аюулгүй хөрөнгийн эрэлт өндөр хэвээр байгааг илэрхийлж байгаа ч нөгөө талдаа ХНБ-ны хүү өсгөх хүлээлт нь алтны үнийн хэлбэлзэлд нөлөөлж байна.

Нүүрсний хувьд үнэ харьцангуй тогтвортой боловч бага зэрэг өсөх хандлагатай буюу $236–$243 орчимд хэлбэлзэж, 2027 онд $248 хүрэх төлөвтэй байна. Энэ нь Хятадын эрчим хүчний эрэлт болон дотоодын олборлолт, гангийн үйлдвэрлэлтэй уялдан нүүрсний хэрэгцээ тогтвортой хадгалагдаж байгааг илтгэнэ.

III. ДОТООД ЭДИЙН ЗАСАГ

3.1. Эдийн засгийн өсөлт

Эдийн засгийн өсөлт 2026 оны 1-р улиралд 7.9% гарлаа. Энэ нь өмнөх оны мөн үеийн 2.6%-ийн өсөлттэй харьцуулахад өндөр үзүүлэлт болж байна.

Ийнхүү эдийн засгийн өсөлт эрчимжихэд өмнөх оны мөн үетэй харьцуулахад нүүрс олборлолт, зэсийн баяжмалын үйлдвэрлэл сайжирч уул уурхайн салбарын гүйцэтгэл нэмэгдсэн нь голлон нөлөөлсөн байна. Тодруулбал, эдийн засгийн өсөлтөд уул уурхайн салбарын өсөлт (33.6%) 5.0 нэгж хувийг дангаар бүрдүүлсэн бөгөөд үүнтэй уялдан тээврийн салбар (23.8%) эрчимжиж эдийн засгийн өсөлтөд 1.1 нэгж хувийг бүрдүүлжээ.

График 3 Монголын эдийн засгийн өсөлт, 1-р улиралд



Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хүснэгт 2 Эдийн засгийн өсөлтөд салбаруудын оролцоо, 2026 оны улирлын байдлаар

ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТ, САЛБАРААР	Оролцоо	Жилийн өсөлт
ДНБ	**7.9%**	
ХАА	0.4%	11.4%
Уул уурхай, олборлолт	5.0%	**33.6%**
Боловсруулах үйлдвэрлэл	-0.4%	-6.6%
Цахилгаан, хий, уур, агааржуулалт	0.4%	8.0%
Барилга	0.1%	9.5%
Худалдаа	-0.1%	-0.8%
Тээвэр	1.1%	**23.8%**
Мэдээлэл холбоо	0.3%	6.6%
Үйлчилгээний бусад	0.9%	2.7%
Бүтээгдэхүүний цэвэр татвар	0.2%	1.1%

Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо

Хөдөө аж ахуйн салбарын (11.4%) өсөлтөд үзүүлэх нөлөө буурч 0.4 нэгжид хүрсэн нь салбарын үйлдвэрлэл өмнөх жилийн түвшинд тогтворжсоныг илтгэж байна. Харин

худалдаа (-0.8%), үйлдвэрлэлийн салбар (-6.6%) нийт эдийн засгийн өсөлтөд 0.5 хувийн сөрөг нөлөө үзүүлсэн *бөгөөд Худалдан авалтын менежрийн ерөнхий индекс сүүлийн улирлуудад дараалан агшаад байгаа (Монголбанк, 2026.05) нь* дотоод эрэлт суларч буйг илтгэж байна *(Тухайн салбарын жилийн өсөлтийн хувийг хаалтанд илэрхийлэв).*

3.2. Инфляц

Хэрэглээний үнийн индекс (ХҮИ) 2026 оны 4 дүгээр сард улсын хэмжээнд өмнөх оны мөн үетэй харьцуулахад 10.1%, өмнөх сараас 2.8%-иар өсөж, инфляц эрчимжлээ.

Инфляц ийнхүү төв банкны зорилтот интервалаас давж өсөхөд нийлүүлэлтийн шалтгаантай инфляц голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, инфляц өмнөх сараас 2.8 хувиар эрчимжсэний 1.3 нэгж хувийг махны үнийн өсөлт, 0.7 нэгж хувийг нефтийн бүтээгдэхүүний үнийн өсөлт бүрдүүлжээ. Бүтээгдэхүүн тус бүрээр үнийн өсөлтийг задлан авч үзвэл мах махан бүтээгдэхүүний үнэ өмнөх оны мөн үеэс 38%-иар, өмнөх сараас 11%-иар өссөн бол шатахууны үнэ өмнөх оны мөн үеэс 17%-иар, өмнөх сараас 11%-иар тус тус өссөн байна.

График 4 Инфляц ба Бодлогын хүү



Эх сурвалж: Монголбанк, УСХ

Цаашид “Хүнсний хувьсгал” хөдөлгөөний нөлөөгөөр хүнсний нийлүүлэлт нэмэгдэж, дотоодын хүнсний үнийн өсөлт буурах хүлээлттэй байгаа бол шатахууны нийлүүлэлт, үнийн тогтвортой байдлыг хангах чиглэлд хийгдэж буй ЗГ-ын гэрээ хэлэлцээрийн үр дүнд дизель түлш, АИ-92 автобензиний үнэ дахин өсөхөөргүй байна. Иймд оны сүүл хагаст инфляц саарах, эргэн нэг оронтой тоонд хүрэх хүлээлттэй байна.

3.3. Улсын төсөв

2026 оны эхний 4 сарын байдлаар улсын төсвийн тэнцэл 1.4 их наяд төгрөгийн алдагдалтай гарлаа. Төсвийн алдагдал нэмэгдэхэд төсвийн нийт зарлага өмнөх оны мөн үеэс 21.4%-иар буюу 1.8 их наяд төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлжээ.

Улсын төсвийн зардал өсөхөд урсгал шилжүүлэг өмнөх оны мөн үеэс 328.5 тэрбум төгрөгөөр буюу 8.3%-иар, хөрөнгийн зардал 877.7 тэрбум төгрөгөөр (2.2 дахин), бараа үйлчилгээний зардал 493.5 тэрбум төгрөгөөр буюу 15.9%-иар тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

График 5 Улсын төсөв



Эх сурвалж: УСХ

Харин төсвийн тэнцвэржүүлсэн орлого 8.9 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 459.7 тэрбум төгрөгөөр буюу 5.4%-иар өсөв. Төсвийн орлогын өсөлтөд нийгмийн даатгалын орлого 290.1 тэрбум төгрөгөөр (17.6%), НӨАТ 105.8 тэрбум төгрөгөөр (5.8%) өссөн нь голлон нөлөөлсөн байна. Харин орлогын албан татварын орлого 148.7 тэрбум төгрөгөөр (5.7%), онцгой албан татварын орлого 108.3 тэрбум төгрөгөөр (28.6%) буурсан нь сөргөөр нөлөөлжээ.

3.4. Мөнгөний нийлүүлэлт

2026 оны 4 дүгээр сарын эцэст мөнгөний нийлүүлэлт өмнөх оны мөн үетэй харьцуулахад 25.3%-иар өсөж 51.0 их наяд төгрөгт хүрлээ. Мөнгөний нийлүүлэлт өсөхөд эх үүсвэр (пассив) талаас төгрөгийн хадгаламж, төгрөгийн харилцах болон валютын харилцах өссөн нь голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, төгрөгийн хадгаламж 27.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 5.5 их наяд төгрөгөөр буюу 24.9%-иар өссөн бол төгрөгийн харилцах 11.3 их наяд төгрөгт хүрч 2.3 их наяд төгрөгөөр буюу 26.1%-иар, валютын харилцах 5.7 их наяд төгрөгт хүрч 2.0 их наяд төгрөгөөр буюу 56.0%-иар тус тус өссөн байна. Харин валютын хадгаламж 5.6 их наяд төгрөгт хүрч 347.8 тэрбум төгрөгөөр буюу 6.7%-иар өссөн байна.Төгрөгийн хадгаламжийн 81.4%-ийг иргэдийн хадгаламж, 18.6%-ийг аж ахуйн нэгж, байгууллагын хадгаламж бүрдүүлж байна.

Мөнгөний нийлүүлэлтийн өсөлтөд байршуулалт (актив) талаас гадаад цэвэр актив болон зээлийн өсөлт голлон нөлөөлсөн байна. Тухайлбал, төлбөрийн тэнцэл ашигтай гарч, гадаад цэвэр актив 2026 оны 4 дүгээр сарын эцэст 11.2 их наяд төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 6.3 их наяд төгрөгөөр буюу 2.3 дахин өссөн байна. Түүнчлэн зээлийн

өсөлт үргэлжилж, дотоод цэвэр актив 39.8 их наяд төгрөгт хүрч 4.0 их наяд төгрөгөөр буюу 11.2%-иар өссөн нь мөнгөний нийлүүлэлтийн өсөлтийг дэмжжээ.

График 6 Мөнгөний нийлүүлэлт



Эх сурвалж: УСХ

3.5. Нийт зээл

2026 оны 4-р сарын байдлаар банкны салбарын нийт зээлийн үлдэгдэл 46.3 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 6.4 их наяд төгрөгөөр буюу 16.2%-иар өсжээ. Нийт зээлийн үлдэгдлийн 60.5% нь иргэдийн зээл байгаа бол 38.7% нь аж ахуй нэгж байгууллагын зээл байна.

Энэ оны 4-р сард иргэдийн зээлийн үлдэгдэл 27.7 их наяд төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 17%-иар өссөн бол байгууллагын зээлийн үлдэгдэл 17.9 их наяд төгрөг болж 21.1%-иар өсжээ.

Нийт зээлийн 5.2% буюу 2.4 их наяд төгрөг нь чанаргүй зээл байгаа бөгөөд өмнөх оны мөн үеэс 344.5 тэрбум төгрөгөөр (16.6%) өсжээ. Хэдийгээр чанаргүй зээлийн үлдэгдэл өссөн ч нийт зээлд эзлэх хувь өмнөх оны мөн үетэй харьцуулахад өөрчлөлтгүй байна. Харин анхаарал хандуулах зээлийн үлдэгдэл 1.4 их наяд төгрөг болж өмнөх оноос 9.7%-иар өссөн бөгөөд нийт зээлийн 3%-ийг эзэлж байна.

График 7 Банкны салбарын зээл



Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

3.6. Гадаад худалдаа

2026 оны эхний 4 сарын урьдчилсан гүйцэтгэлээр нийт экспорт 6,813 сая ам.долларыг давж өмнөх оны мөн үеэс 60.6%-аар өссөн бол нийт импорт 3,669 сая ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 3.1%-аар өсжээ. Иймхүү экспортын өсөлт өндөр хэвээр хадгалагдсанаар гадаад худалдааны тэнцэл 3,144 сая ам.долларын ашигтай гарлаа.

График 8 Нийт экспорт ба импорт



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Экспортын өсөлтийн 40.2 нэгж хувийг зэсийн баяжмалын орлогын өсөлт, харин үлдсэн 17.8 нэгж хувийг нүүрсний экспортын орлого тайлбарлаж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад зэсийн баяжмалын орлого 2.2 дахин өссөн бол, нүүрсний экспортын орлого 43.0%-аар, алтны экспортын орлого 36.2%-аар өссөн байна.

График 9 Экспортын голлох бүтээгдэхүүн



2023 оны 3-р сард Оюу Толгойн далд уурхай ашиглалтад орсноор зэсийн баяжмалын агууламж сайжирч, улмаар зэсийн хилийн үнэ тасралтгүй өсөж 2026 оны 4-р сарын байдлаар тонн тутамд 3,728 ам.долларт хүрэв *(жилийн өмнөх мөн үеэс 61.6%-аар, 3 жилийн өмнөх мөн үеэс 2.1 дахин өссөн үзүүлэлт юм).* Зэсийн экспортын биет хэмжээ эхний 4 сарын хуримтлагдсан дүнгээр 890 мянган тонн-д хүрсэн ба энэ нь оны өмнөх мөн үеэс 37.2%-аар, 3 жилийн өмнөх мөн үеэс 84.1%-аар өссөн үзүүлэлт юм. Ийнхүү биет хэмжээ болон хилийн үнэ хоёул өссөн хэвээр байгаа нь зэсийн баяжмалын орлого нийт экспортын орлогод давамгайлах байр суурь эзлэх нөлөөллийг үзүүлж байна.

График 10 Зэсийн баяжмалын экспортын биет хэмжээ, үнийн түвшин



Харин нүүрсний экспортын хувьд үнэ тогтворжиж, биет хэмжээ өсөх хандлагатай байна. Тухайлбал эхний дөрвөн сард нийт 37.4 сая тонн чулуун нүүрс экспортолсон нь өмнөх оны мөн үеэс 64.3%-аар өссөн үр дүн бол хилийн үнэ сарын цэврээр тонн тутамд 68.6 ам.долларт хүрснээр жилийн өмнөх мөн үетэй адил түвшинд тогтворжоод байна.

График 11 Чулуун нүүрсний экспортын биет хэмжээ, үнийн түвшин



Эх сурвалж: Гаалийн Ерөнхий Газар

Олон улсын геополитикийн тогтворгүй нөхцөл байдлаас шалтгаалан шатахууны үнэ өссөний зэрэгцээ шатахууны нөөцийг нэмэгдүүлж нийлүүлэлтийг тогтвортой хадгалах зорилгоор шатахууны нийт импорт өсөөд байна . Тухайлбал 4-р сард нефтийн бараа буюу шатахууны импорт 22.7%-аар өссөн, үүний 17.2% нь биет хэмжээний, харин 4.7% нь үнийн өсөлтөөр тайлбарлагдаж байна. Мөн шатахууны өсөлтийг бүрэлдэхүүн хэсгээр задлан үзвэл зуны дизель түлшний өсөлт 13.0 нэгж хувийг, харин АИ-92 шатахууны өсөлт 10.4 нэгж хувийг голчлон бүрдүүлсэн байна.

Монгол улсын импортын дизель шатахууны үнэ Сингапурын биржийн үнийг удирдлага болгон тогтдог бөгөөд олон улсад шатахууныг тойрсон асуудлаас шалтгаалж 5-р сараас эхлэн дизелийн үнэ литр тутамд 6,700 төгрөгт хүрэх эрсдэл өндөр байв. Улмаар Засгийн газраас цаг үеийн нөхцөл байдалтай холбоотой арга хэмжээ авч ОХУ-ын талтай уулзсанаар 2026 оныг дуустал дизелийг ОХУ-ийн дотоод биржийн үнээр буюу тонн тутмыг 1,200 ам.доллараар худалдан авах хэлэлцээрийг амжилттай хийснээр дотоодод борлуулах үнэ литр тутамд 4,300 төгрөгт тогтвортой хадгалагдах боломж бүрдэв (АУЭБЯ, 2026.05). Мөн өргөн хэрэглээний АИ-92 шатахууны хувьд тогтвортой үнээр буюу тонн тутмыг 705 ам.доллараар авах урт хугацааны гэрээ хэвээр үйлчилж байгаа учраас ойрын саруудад шатахууны үнийн өсөлтөөс шалтгаалсан дарамт буурахаар байна.

График 12 Импортын голлох бүтээгдэхүүн



Эх сурвалж: : Гаалийн Ерөнхий Газар

3.7. Төлбөрийн тэнцэл, нэрлэсэн ханш

Гадаад худалдааны нөхцөл байдал харьцангуй тогтвортой хадгалагдаж, урсгал дансны ашиг 3-р сард хуримтлагдсан дүнгээр 413 сая ам.долларт хүрч, төлбөрийн тэнцэл 96 сая ам.долларын ашигтай гарчээ.

Улмаар 2026 оны 4-р сард гадаад валютын албан нөөц 7,327 сая ам.долларт буюу түүхэн дээд түвшинд хүрлээ. Энэ нь өмнөх оны мөн үеэс 42.7%-аар, өмнөх сараас 1.9%-аар, харин оны эхнээс 4.6%-аар өссөн үзүүлэлт болж байна. Сүүлийн саруудад ийнхүү валютын нөөц өсөлт өндөртэй байгаа нь экспортын орлого нэмэгдэж, гадаадын зах зээлд гаргаж буй бондуудын нөлөөллөөр хөрөнгийн орох урсгал сайн байгаатай холбоотой байна.

Олон улсад гадаад валютын албан нөөцийн хэмжээг тодорхойлохдоо импортыг хангах бололцоогоор жишиг болгон авч үздэг ба Монгол улсын хувьд 4-р сарын байдлаарх ГВАН нь 9 сарын импортын хэрэгцээг хангах хэмжээнд буюу дэлхийн дундажтай ойролцоо байна. Дэлхийн банкны гаргасан статистикаар 2024 оны эцэст орлогын түвшнээр ангилан харвал дундаж болон өндөр орлоготой улсуудад 9 сар, дунджаас дээш орлоготой улсуудад 10 сар, дунджаас доогуур орлоготой улсуудад 7 сар, харин бага орлоготой улсуудад 4 сар байдаг байна.

График 13 Төлбөрийн тэнцэл



Эх сурвалж: Монголбанк

ГОЛОМТ БАНК
Сайн сайхныг санхүүжүүлнэ

ЭДИЙН ЗАСГИЙН СУДАЛГААНЫ ХЭЛТЭС

7575-1111 /1277/
eru@golomtbank.com
www.dua.golomtbank.com

Голомт банкны төв байр,
Сүхбаатарын талбай 5, Ш/х-22,
Улаанбаатар 15160, Монгол Улс
SWIFT: GLMT MNUB

АНХААРУУЛГА

Голомт банкны Эдийн засгийн судалгааны хэлтэс нь Монгол улсын макро эдийн засгийг бүхэлд нь хамарч судалдаг билээ. Энэхүү тайлан нь макро эдийн засгийн хамгийн сүүлийн үеийн өгөгдлийг ашигласан болно. Энэхүү тайланд тусгагдсан агуулга, санаа нь Голомт банкны байр суурийг илэрхийлэх албагүй болно. Голомт банкнаас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр энэ тайлангийн аль нэг хэсгийг хуулбарлах, системд хадгалах, ямар нэг хэлбэрээр дамжуулах, цахим механик хэлбэрээр хувилах, бичлэг хийхийг хориглоно.